

Огноо 2024.07.02

№ 007/08

УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ ТУХАЙ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024.06.1-ны 221/ма2024/0374 тоот Магадлалд гомдол гаргах тухай

3.Нарангийн нэхэмжлэлтэй, хариуцагч Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Гурав дагч этгээд Л.Батбаатар нарт холбогдох захиргааны хэргийг, давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэхдээ ЗХШХШТХуулийн 123.2.1-д зааснаар хуулийг зөрүүтэй хэрэглэсэн тул шүүхийн шийдвэр магадлал, хууль ёсны бөгөөд үндэслэл байх шаардлагыг хангаагүй гэж 3 дагч этгээдийн өмгөөлөгч нь дараах үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргаж байна. Үүнд:

Нэг..Анхан болон давж заалдах шатны шүүх, Хэрэг маргааныг материаллаг болон процессийн эрх зүйн хэм хэмжээг тэдгээрийн агуулга, зорилгод нийцүүлэн, оновчтой, хуулийг зөв хэрэглэсэн тохиолдолд шийдвэр хууль ёсны байх зарчмыг хангадаг.

Гэтэл материаллаг эрх зүйн хэм хэмжээ болон процессын эрх зүйн хэм хэмжээ, олон хууль журмыг зөрчиж хэргийг шийдвэрлэсэн нь шүүхийн шийдвэр хууль ёсны байх хуулийн заалтыг хангасангүй. Учир нь:

Нэхэмжлэгч 3.Наран өөрийн өмч, маргааны зүйл болсон ү-2202025495 үл хөдлөх эд хөрөнгөө 2018.01.27-ны өдөр Д.Мөнхбат-д 385,000,000 худалдахаар тохирч, түүнтэй үл хөдлөх худалдах худалдан авах гэрээ, төлбөрийн тухай гэрээ байгуулсныг үндэслэн 2018.01.31-ны Д.Мөнхбат өмчлөгчөөр бүртгэгдэж гэрчилгээ олгогдсон байдаг????????

Улмаар Д.Мөнхбат ???????? 2018.06.23-2018.07.23-хүртэл 1 сарын хугацаатай 4 хувийн хүүтэй гээр 77,000,000 төгрөгийг Здагч этгээд болох иргэн Л.Батбаатараас Зээлэхээр тохиролцон Зээлийн гэрээ байгуулж дээрх Ү-2202025495 тоот хөрөнгийг барьцаанд тавьж зохих журмын дагуу бүртгүүлсэн, мөнгөө өгөөгүй тул шүүх-д хандсан

а.Хан-уул иргэний хэргийн шүүх 2019.12.02-ны 2580 Зээлийн гэрээний үүрэгт 83,283,200,0 төгрөгийг Д.Мөнхбатаас гаргуулан Л.Батбаатарт олгох, үүргийн гүйцэтгэлийг барьцааны хөрөнгөөр хангуулах шийдвэр гаргасан, 2020.02.02-ны өдөр Албадан гүйцэтгэх 02840 Захирамж гарсан.

Улмаар 2020.10.02-ны өдөр Албадан дуудлага худалдаагаар худалдахаар нийтэд зарласан боловч борлогдоогүй тул 2020.10.29-ны 2 дах худалдаагаар 221.785,000 төгрөгөөр Л.Батбаатар өөрөө худалдан авсан.

Гэтэл 3.Наран 2021 онд Захиргааны хэргийн шүүхэд 3.Нарангаас Д.Мөнхбат-д шилжсэн шилжилтийг бүртгэгсэнийг хүчингүй болгон өгнө үү гэсэн шаардлагыг 2021.10.21-ны 0690 шийдвэрээр хэрэгсэхгүй болгон шийдсэн.

Харин дээрх дуудлага худалдааны ялагч Л.Батбаатар 221,785,000 төгрөгөө тушаагаад 2-3 жил болж байгаа ч хөрөнгөө олж чөлөөлж авч чадалгүй өдий ч хүрч байгаа учир шалтгаан нь 3.Наран Д.Мөнхбатаас дуудлага худалдааны дагуу Л.Батбаатарт шилжсэн **Ү-2202025495** хөрөнгийг хууль бус шилжсэн гэж үзэж цагдаа сэргийлэхэд хандан хөрөнгийг чөлөөлж өгөхгүй өдий хүрсэн.

Улмаар Захиргааны хэргийн шүүхэд 3.Наран, Д.Мөнхбатаас Л.Батбаатарт шилжсэн шилжилтийг бүртгэсэн Чингэлтэй бүртгэлийг хүчингүй болгож өгнө үү гэсэн нэхэмжлэл гаргасныг анхан шатны шүүх түдгэлзүүлж, Давах шатны шүүх нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэхдээ:

Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүд, Шүүхийн шийдвэр, Цагдаагийн эрх бүхий албан тушаалтны хөрөнгө шилжүүлэх тухай албан тоотууд гүйцэтгэх газрын албан бичгүүд зэрэг нотлох баримт зэргийг харгалзан үзэлгүй хуулийг зөрүүтэй хэрэглэсэн гэж үзэж байна.

Тухайн хөрөнгийг Д.Мөнхбат дээр дурдсанчлан 2018.01.31-нд өөрийн нэр дээр бүртгүүлсэн байсныг Үндэслэн Л.Батбаатар 2018.06.23-нд барьцаалан, Түүнд мөнгө зээлдүүлсэн. Цаашид Л.Батбаатар шүүхэд хандсанаар дээрх шийдвэрүүд гарсан.

Өөрөөр хэлбэл 3.Наран Д.Мөнхбат-д Ү-2202025495 хөрөнгийг өөрөө гэрээ хийгээд шилжүүлсэн ч мөнгөө дутуу авсан залилуулсан үйлдэл нь эрүүгийн хэргийн асуудал байгааг харгалзан үзсэнгүй, /энэ талаархи тайлбар, гэрээ, хэрэгт хангалттай байгаа/ төдийгүй 2021.10.21-ны 0690 гэсэн дугаартай Захиргааны хэргийн анхан шатны шүүгч О.Оюунгэрэл шүүгчийн шийдвэрийн үндэслэх хэсгийн /7 дугаар/ дугаар тал ын доороос 5 дах логол мөрөнд мөн дүгнэгдсэн байгаа болно

Давахын Магалдалын хангагдсан Үндэслэл нь: **Магадлалын 5 хуудасны** Хууль хэрэглээсний талаар гэх догол мөрний 2.1-д:

Хэрэгт авагдсан баримтаас үзэхэд **2017.07.24-ны өдөр 17.3-д зааснаар Д.Мөнхбат-д холбогдуулан Эрүүгийн хэрэг бүртгэл нээж, маргааны зүйл болох Ү-2202025495 үл хөдлөх хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах саналыг Чингэлтэй прокурорын газарт 2018.07.17-ны өдөр танилцуулжээ гээд.**

Уг хүсэлтийг Прокурор хянаад **2018.07.18-ны өдөр Прокурорын зөвшөөрөл олгосон тухай шийдвэр гаргажээ. Үүний дараа 2018.07.26-ны өдөр хязгаарлалтыг Улсын бүртгэл бүртгэсэн байна.**

Дээрх хязгаарлалт цуцлагдаагүй байсан байна. Өөрөөр хэлбэл Магадлалын Хянавал хэсгийн 1.2-д дурдсан /Чингэлтэй бүртгэлийн хэлтсийн

и/төлөөлөгчөөс:2022.10.14-ны Өмчлөх эрх шилжүүлэх тухай, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын албан тоот ,Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн эрх бүхий албан тушаалтны 2022.11.04-ны 4/8469 албан тоотуудаар Мөнхбатаас Л.Батбаатарт шилжүүлэхийг мэдэгдье/ шилжсэн шилжилт нь хууль зөрчсөн байна.гэж үзэж өөрөөр хэлбэл Прокурорын хязгаарлалт байхад Улсын бүртгэл Д.Мөнхбатаас Л.Батбаатарт шилжин бүртгэгджээ гэж дүгнэхдээ:

Эд хөрөнгийн шилжилтийг хязгаарласан Прокурорын хязгаарлалт тавагдахаас 6 сарны өмнө нэхэмжлэгч З.Наран өөрөө Д.Мөнхбат-д хөрөнгөө шилжүүлсэн байсан нь Прокурорын хязгаарлалтын Зөвшөөрөл 2018.07.18-нд тавигдсан байгаагаар тогтоогдож байхад


Анзааран үзэлгүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль,Бүртгэлийн тухай хууль,Иргэний хууль зэрэг олон хууль тогтоомжийг зөрүүтэй хэрэглэж нэхэмжлэлийг хангасан гэж гомдол гаргаж байна. Иймээс Магадлалыг хянаж өгнө үү

ГОМДОЛ ГАРГАСАН

ӨМГӨӨЛӨГЧ

"прокурорын мэдэгдэл

УТХ төлсөн баримт хавсаргав



Т.ДЭЛГЭРБАЯР/99110914/